

Түүх 4 : Бэлэвсэн эмэгтэйн хоёр денар

Библийн эшлэл
[Марк 12:43]

Есүс шавь нараа дуудаад – Үнэнээр Би та нарт хэлье.
Ядуу бэлэвсэн энэ эмэгтэй эрдэнэсийн санд өгсөн бүх хүнээс ихийг өглөө.

Нэгэн өдөр, Есүс дагалдагч нартайгаа хамт сүмд очив. Тэгээд хүмүүсийн өргөл өргөж байгааг ажиглан хараад сууж байв. Олон хүмүүсийн дундаас нэгэн баян урд гарч ирлээ. Баян хүн мөнгөний хүүдийгээ нээн олон хүний нүдэн дээр их мөнгөтэйгөө гайхуулан харуулав. Тэгээд мөнгөний хүүдийнээсээ хэдийг сугалан өргөлийн хайрцаганд хийчихэв. Баяныг явсаны дараагаар ядруухан хувцасласан нэгэн ядуу эмэгтэй өргөл өргөхөөр ирэв. Эргэн тойронд нь олон хүн байсан боловч хэн ч түүнийг тоож харахгүй байв. Эмэгтэй чин сэтгэлээсээ бэлдсэн хоёр зоосоо өргөлийн хайрцаганд хийв. Эмэгтэйн өргөсөн зоос бол манайхаар 200-300 төгрөгтэй тэнцэх бага хэмжээний мөнгө байлаа. Өргөлийн хайрцаганд зоос унаж байгаа чимээг сонссон хүмүүс эмэгтэйг шоолж эхлэв. Энэ бүх зүйлийг чимээгүйхэн хараад сууж байсан хүн байлаа. Тэр бол Есүс байв. Есүс дагалдагчидаа дуудан ингэж хэлэв. “Түрүүлж өргөл өргөсөн баян хүнээс илүү сая өргөсөн эмэгтэйн өргөл хамгийн их нь байлаа.” Шавь нар нь Есүсээс ингэж асуув. “Есүс ээ, тэр чинь юу гэсэн үг вэ? Баян их хэмжээний мөнгийг өргөлийн хайрцаганд хийсэн байхад тэр эмэгтэй дөнгөж хоёрхон зоос хийсэн шүү дээ.” Есүс тэдэнд ингэж хариулав. “Тэр баян өөртөө байгаа мөнгөнийхөө өчүүхэн хэсгийг өргөсөн байхад, харин тэр эмэгтэй өөртөө байгаа бүхнээ Бурханд өргөсөн.” Бурхан бидний гаднах төрхийг хардаггүй. Өргөл өргөх үед хэдийг өргөсөн бэ? гэдгийг ч хардаггүй. Харин Бурханд хэр их хайртайг, бид чин сэтгэлээсээ Бурханд өргөж чадаж байгаа эсэхийг л хардаг юм.



Бүтээлч байцгаая 1. Доорх асуултанд хариулаарай.

а. Баян хүн ямар өргөл өргөсөн бэ?

б. Ядуу бэлэвсэн эмэгтэй ямар өргөл өргөсөн бэ?

с. Өнөөдрийн түүхээс юу сурсан бэ?

● **Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй. (Марк 12:43)**

Есүс шавь нараа дуудаад Ядуу бэлэвсэн энэ эмэгтэй эрдэнэсийн санд өгсөн бүх хүнээс ихийг өглөө.

Бүтээлч байцгаа 2. Есүс шавь нартаа хэлсэн үгийг олоорой.

Т	Й	Д	У	Р	И	Я	Б	А	Х	Г	Ө	М	Ү	Н	Э	С	Л	В
®	★	☞	☎	¥	♪	←	◀	◐	☞	↓	€	◎	#	&	♠	♣	≠	◁

←	☞	☎	☎		◀	♠	≠	♠	◁	♣	♠	&		♠	&	♠		

♠	◎	♠	↓	®	♠	★		♠	¥	☞	♠	&	♠	♣	♪	★	&	

♣	◐	&	☞		€	↓	♣	€	&		◀	#	☞		☞	#	&	♠	♠	♣

♪	☞	♪	★	↓		€	↓	≠	€	€		.

	А		К		12	:	43
--	---	--	---	--	----	---	----